



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/346

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Дугарсүрэнгийн Мөнхдалайн эзэмшлийн Хэрлэн сумын 2-р баг /Булаг/ Баатрууд гудамж М-20-16 тоот байрлах гэр орон сууцны хашааны зориулалттай 516 мкв газрыг иргэн Мягмарбаатарын Дагват 47 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн М.Дагвын эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн М.Дагват үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/231 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ